

**НИЙГМИЙН ДЭВШИЛ ЭМЭГТЭЙЧҮҮД ХӨДӨЛГӨӨНИЙ
ТӨВ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ**

**“ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ИРГЭДИЙН ОРОЛЦОО”
МОНИТОРИНГИЙН ТӨСЛИЙН ТАЙЛАН**

2013 он

Талархал

Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах тухай Төсвийн тухай хуулийн 63-р зүйлийн хэрэгжилтэд мониторинг хийх төслийг дэмжин арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Нээлттэй Нийгэм Форумд гүн талархал илэрхийлье.

Түүнчлэн, мониторингийн явцад холбогдох мэдээ мэдээлэл, баримт материалтай танилцах боломж олгосон Төв аймгийн нутгийн удирдлагын байгууллага, тэдгээрийн ажилтнуудад талархаж, орон нутгаа хөгжүүлэх үйлсэд нь амжилт ерөөе.

ГАРЧИГ

МОНИТОРИНГИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА.....	4
МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД.....	4
МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ.....	5
МОНИТОРИНГИЙН ДҮН.....	6
ДҮГНЭЛТ.....	13
ЗӨВЛӨМЖ.....	14
НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	15

МОНИТОРИНГИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

2011 онд шинэчлэн батлагдсан Төсвийн тухай хуулиар орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог бий болгох эрх зүйн орчин бүрдсэн юм. Тухайлбал, Төсвийн тухай хуульд орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах талаар тусгайлан 63-р зүйл оруулж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн дунд нээлттэй санал асуулга явуулахаар тусгажээ. Түүнчлэн, хуулийн энэхүү зүйлийн дагуу иргэдийн өгсөн саналыг баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэн эрэмбэлэх, эрэмбэлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь саналыг хэлэлцэж, батлах шаардлагатай юм. Ийнхүү Төсвийн тухай хуульд дээрх заалтуудыг оруулснаар иргэд төсвөө хянан зарцуулах боломжтой болсон ч орон нутгийн төсөвт олон нийтийн оролцоо хангалтгүй хэвээр байна. Үүний учир шалтгааныг тодорхойлж, хуулийн хэрэгжилтийг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилгоор Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн /НДЭХ/-ий Төв аймаг дахь салбараас Төсвийн тухай хуулийн 63-р зүйлийн хэрэгжилтэд мониторинг хийх “Төсөвт –Иргэдийн оролцоо” төслийг хэрэгжүүлсэн юм.

МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Зорилго: Төсвийн тухай хуулийн “орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах” тухай 63-р зүйлийн хэрэгжилтэд мониторинг хийх.

Зорилтууд:

1. Багийн Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар багт олон нийтийн нээлттэй санал асуулга явуулах буюу 63-р зүйлийн 1 дэх заалтын хэрэгжилтэд мониторинг хийх
2. Нээлттэй санал асуулгын явцад болон багийн иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгох буюу 63-р зүйлийн 2 дахь заалтын хэрэгжилтэд мониторинг хийх
3. Багийн иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сумын Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх буюу 63-р зүйлийн 3 дахь заалтын хэрэгжилтэд мониторинг хийх

4. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын Тамгын газраас өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцэж, төсвийн төсөлд тусган батлах буюу 63-р зүйлийн 4 дэхь заалтын хэрэгжилтэд мониторинг хийх

МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ

Мониторингийг 2013 оны 10-р сараас 2014 оны 4-р сарын хооронд Төв аймгийн Батсүмбэр, Баяндэлгэр болон Баянчандмань сумдад хэрэгжүүлсэн юм. Ингэхдээ Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалаар баталсан Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх Орон нутгийн төсөв боловсруулах журмын “төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог хангах” тухай зүйл дээрх сумдад хэрхэн хэрэгжиж байгаа талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийсэн юм. Энэ хүрээнд мэдээлэл цуглуулах дараах аргыг ашигласан болно:

1. Баримт бичгийн судалгаа: Хуулийн 63.1, 63.2, 63.3, 63.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор улсын болон орон нутгийн түвшинд гаргасан дүрэм, журам, тогтоол, шийдвэр болон холбогдох бусад баримт бичгийг судалж, орон нутгийн төсөвт иргэдийн оролцоог хангах эрхзүйн зохицуулалт болон түүний хэрэгжилтийг судалсан болно. Баримт бичгийн судалгааны хүрээнд, мониторингод хамруулсан 3 сумын 9 багийн олон нийтийн нээлттэй санал асуулга болон иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны зохион байгуулалт, тэдгээрт оролцсон иргэдийн хувь, тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн төсөл, арга хэмжээ зэргийн талаар мэдээлэл цуглуулав.
2. Санал асуулга: Мониторингод хамруулсан 3 сумын 700 иргэнээс санал асуулга авч, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын талаарх тэдний ойлголт, 2012 онд зохион байгуулсан багийн нээлттэй санал асуулга болон багийн иргэдийн Нийтийн Хуралд оролцсон эсэх талаар асууж, баримт бичгийн судалгааны хүрээнд олсон мэдээллийг шалган баталгаажуулав.
3. Ярилцлага: Хуулийн 63.1, 63.2, 63.3, 63.4 дэх заалтуудын хэрэгжилт, цаашид анхаарах асуудлын талаар 3 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, 9 багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга, багийн Засаг дарга, орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхөд арга зүйн зөвлөмж өгч дүгнэлт гаргах үүрэгтэй Ажлын хэсгийн гишүүд болон багийн иргэдтэй ярилцлага хийсэн болно.
4. Ажиглалт: Хуулийн 63.1, 63.2 дэх заалтын хэрэгжилтийн талаар мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд Батсүмбэр сумын Мандал багт нээлттэй санал асуулгыг, Баянчандмань сумын Эрдэнэ багт иргэдийн Нийтийн Хурлыг хэрхэн зохион байгуулсныг ажиглав. Түүнчлэн, 63.3 дахь заалтын хэрэгжилттэй танилцахын тулд орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхөд арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулсан Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ажлын

хэсгийн үйл ажиллагааг, 63.4 дэх заалтын хэрэгжилттэй танилцахын тулд Батсүмбэр болон Баянчандмань сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааныг тус тус ажиглав.

МОНИТОРИНГИЙН ДҮН

Төсвийн үйл явцад иргэдийн оролцоог хангахад орон нутгийн удирдлагын гүйцэтгэх үүргийг Орон нутгийн төсөв боловсруулах журамд тодорхой зааж өгсөн байна. Тухайлбал, багийн Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар багт олон нийтийн нээлттэй санал асуулга явуулах

63.1. Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.

буюу Төсвийн тухай хуулийн 63-р зүйлийн 1-р заалтыг хэрэгжүүлэхдээ иргэдийн саналыг асуулгын хуудсаар, бүлгийн ярилцлагаар болон цахим хэлбэрээр авахаар зохицуулжээ. Саналыг асуулгын хуудсаар авахдаа тусгай маягт ашиглах бөгөөд маягтыг багийн айл өрх бүрт жил бүрийн 1-р улиралд багтаан хүргүүлж, 2-р улирлын эхний 30 хоногт саналыг нь авахаар тусгасан юм.

Журмын дагуу 2012 онд Батсүмбэр суманд асуулгын хуудас болон цахим хэлбэр ашиглан насанд хүрсэн иргэдийн 17 орчим хувиас нь санал авсан байна. Баяндэлгэр суманд олон нийтийн саналыг цахим хэлбэрээр авсан бөгөөд санал асуулгад иргэдийн зөвхөн 2 хувь нь хамрагджээ. Харин Баянчандмань суманд нээлттэй санал асуулга огт явуулаагүй бөгөөд хуулийн 63.2-г заасан багийн иргэдийн Нийтийн Хуралд оролцогсдоос саналыг нь авсан байна. 2012 онд Орон нутгийн төсөв боловсруулах журмын хэрэгжилт ийнхүү хангалтгүй байсанд тус журам он дуусаж байх үед буюу 11-р сард батлагдсан нь нөлөөлсөн юм.

2013 онд Баяндэлгэр болон Батсүмбэр сумын багийн Засаг дарга нар олон нийтийн нээлттэй санал асуулга явуулахдаа журамд заасан санал асуулгын гурван хэлбэрийг ашигласан бөгөөд санал асуулгад оролцсон иргэдийн тоо тус бүр ойролцоогоор 80 ба 30 хувиар нэмэгдсэн юм. Харин Баянчандмань суманд иргэдийн саналыг цахим хэлбэрээр авч, насанд хүрсэн иргэдийн 0.5 орчим хувийг хамруулжээ.

Иргэдийн саналыг авахдаа асуулгын хуудас ашигласан Батсүмбэр болон Баяндэлгэр суманд санал асуулгын маягтыг айл өрхүүдэд хүргүүлэх болон санал авч дуусах журамд заасан хугацааг баримтлаагүй байна. Тухайлбал, 2013 онд Батсүмбэр суманд санал асуулгын хуудсыг айл өрхүүдэд 2-р улиралд хүргүүлж, 3-р улиралд хураан авч нэгтгэсэн бол Баяндэлгэр суманд 4-р улиралд хүргүүлж, мөн улиралд хураан авч нэгтгэжээ.

Нээлттэй санал асуулгын явцад болон багийн иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгох буюу 63-р зүйлийн 2-р заалтыг хэрэгжүүлэх хүрээнд багийн Засаг дарга иргэдийн ирүүлсэн саналыг багийн иргэдийн Нийтийн Хуралд хэлэлцүүлэх урьдчилсан жагсаалт бэлтгэх бөгөөд уг жагсаалтад дараахь мэдээллийг оруулахаар журамд тусгажээ:

63.2. Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

- хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх
- хэдэн хүн ашиг хүртэх
- сумын иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх
- төслийн нийт өртөг

2012 онд багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэх урьдчилсан жагсаалтыг зөвхөн Батсүмбэр сумын Мандал багийн Засаг дарга бэлтгэсэн байна.

2013 онд 3 сумын бүх багийн Засаг дарга нар иргэдийн Нийтийн Хуралд хэлэлцүүлэх урьдчилсан жагсаалт бэлтгэсэн боловч журамд заасны дагуу жагсаалтад тусгах шаардлагатай мэдээллийг бүрэн гүйцэд тусгаагүй аж.

Нээлттэй санал асуулгын явцад болон багийн иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгох буюу 63-р зүйлийн 2-р заалтыг хэрэгжүүлэх хүрээнд багийн Засаг дарга иргэдийн Нийтийн Хурал хуралдахаас 2 долоо хоногийн өмнө иргэдэд зориулж дараах мэдээллийг багт байршуулсан байх талаар журамд тусгажээ:

- тухайн суманд хуваарилагдах хөрөнгийн урьдчилсан тооцоо
- иргэдээс гарсан урьдчилсан жагсаалт
- сумын Засаг даргаас ирүүлсэн тухайн сум, багт хэрэгжүүлэх шаардлагатай хөгжлийн бодлого чиглэлтэй уялдсан төслүүдийн мэдээлэл
- өмнөх жилүүдэд хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний товч мэдээлэл

2012 онд Батсүмбэр сумын Мандал сумын багийн Засаг даргаас бусад Засаг дарга журамд заасан мэдээллийг багийн иргэдийн Нийтийн Хурал хуралдахаас өмнө багт байршуулаагүй болно. 2013 онд мониторингод хамруулсан 3 сумын багийн Засаг дарга нар эдгээр мэдээллээс зөвхөн хоёрыг (иргэдээс гарсан урьдчилсан жагсаалт, өмнөх жилүүдэд хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний мэдээлэл) нь бэлтгэж, багийн иргэдийн Нийтийн Хурал хуралдахаас өмнө 1-3 хоногийн өмнө багт байршуулжээ.

Мөн журамд багийн иргэдийн Нийтийн Хурал дээр багийн Засаг дарга иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, сумын Засаг даргаас ирүүлсэн хөгжлийн бодлоготой уялдсан төслийн санал болон хурлын үеэр иргэдийн дэвшүүлсэн саналыг хэлэлцүүлэхээр тусгажээ.

Эдгээр гурван асуудлаас хөгжлийн бодлоготой уялдсан төслийн саналыг 3 сумын аль ч багт 2012, 2013 онд хэлэлцээгүй юм. Иргэдийн Нийтийн Хурлын явцад оролцогчид өмнөх жилүүдэд хэрэгжсэн эсвэл орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр хориглосон төсөл, хөтөлбөрийг санал болгох¹, үүнээс болж хоорондоо маргалдах, улмаар хуралдааны дэгийг зөрчих явдлууд мониторингийн явцад цөөнгүй гарч байлаа.

Баянчандмань сумын Эрдэнэ багт 2014 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийг сонгохдоо иргэдийн Нийтийн Хуралд ирсэн хүмүүст дугаар бүхий хуудас тараан өгч саналыг нь бичүүлж, тэд нараар гар өргүүлэн эрэмбэлсэн юм. Ингэхэд, шалгуур хангахгүй байна гэсэн үндэсэлэлээр ихэнх саналыг хассан бөгөөд оролцогчид шийдвэр батлах явцад хурлын танхимаас орж гарсан эмх цэгцгүй байдал ажиглагдаж байв.

Түүнчлэн, иргэдийн Нийтийн Хурлын тэмдэглэлийг “Орон нутгийн төсөв боловсруулах журам”-ын хавсралтаар баталсан маягтын дагуу хөтөлж, хурлын ирцийг оролцогчдын гарын үсгээр баталгаажуулах ёстой боловч үүнийг хэрэгжүүлэхгүй байх явдал нэлээдгүй байна. Тухайлбал, 2012 онд иргэдийн Нийтийн Хурлын тэмдэглэлийг зөвхөн Батсүмбэр сумын 2 багт (Мандал, Цогт-Өндөр) журамд заасан маягтын дагуу хөтөлсөн бөгөөд хуралдааны тэмдэглэлийг оролцогчдын гарын үсгээр баталгаажуулсан нэг ч баг мониторингод хамруулсан 3 суманд байгаагүй ажээ. 2013 онд багийн иргэдийн Нийтийн Хурлын тэмдэглэлийг Батсүмбэр сумын бүх багуудад маягтын дагуу бүрэн гүйцэд, Баяндэлгэр сумын багуудад хагас дутуу хөтөлсөн бөгөөд хуралдааны тэмдэглэлийг зөвхөн Батсүмбэр сумын 3 (Мандал, Баянгол, Цогт-Өндөр), Баянчандмань сумын 1 багт (Эрдэнэ) оролцогчдын гарын үсгээр зохиох ёсоор баталгаажуулжээ.


Багийн иргэдийн Нийтийн Хурлаас эрэмбэлэн гаргасан төслийн жагсаалтыг тухайн жилийн 2-р улиралд багтаан сумын Засаг даргад хүргүүлэхээр журамд тусгасан боловч 2012, 2013 онуудад 3 сумын багийн Засаг дарга нар энэ хугацаанд багтааж орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг сумынхаа Засаг даргад хүргүүлээгүй байна.

¹ Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ; улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага; үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал; нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа; зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах; орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ (Төсвийн тухай хуулийн 60.3-р заалт).

Төсвийн тухай хуулийн 63.1-д заасан нээлттэй санал асуулга болон 63.2-т заасан багийн иргэдийн Нийтийн Хурлын үеэр саналаа илэрхийлэх замаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг тодорхойлох явцад иргэдийн оролцоо дараах байдалтай байна:



2012 онд саналаа өгөөгүй гэж хариулсан Батсүмбэр, Баяндэлгэр болон Баянчандмань сумын 400 орчим хүнээс оролцоогүй шалтгааныг нь асуухад дараах тайлбар өгчээ:



Багийн иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сумын Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх буюу 63-р зүйлийн 3-р заалтыг хэрэгжүүлэхдээ дараах шаардлагыг биелүүлсэн байх талаар журамд тусгажээ:

63.3. Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

- багуудаас ирүүлсэн саналыг нэгтгэж, сумын орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг бэлтгэх
- тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдсэн төслийн саналын төсвийн нөлөөллийн тооцоог боловсруулж хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг 60 өдөрт нэгтгэн боловсруулах

- орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхөд төсөв, хөрөнгө оруулалт болон тухайн салбарыг хариуцсан мэргэжилтнүүдийг оролцуулсан арга зүйн зөвлөмж өгч дүгнэлт гаргах үүрэг бүхий 7-оос доошгүй гишүүдээс бүрдэх ажлын хэсгийг томилж ажиллуулах
- эрэмбэлсэн жагсаалтыг үндэслэн журмын хавсралтад заасан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөл тодорхойлох маягт бэлтгэх
- сумын Засаг дарга эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, орон нутгийн төсөв боловсруулах журам"-ын 6.3-т заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гаргаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төсвийн төслийн хамт өргөн мэдүүлэх




Мониторингод хамруулсан гурван сумаас Баяндэлгэр суманд орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх төслийн нэгдсэн жагсаалт бэлтгэхэд арга зүйн зөвлөмж үзүүлэх зорилготой 7-оос доошгүй гишүүнтэй мэргэжлийн ажлын хэсгийг хоёр жил дараалан байгуулаагүй байна.

Сумын Засаг даргын Тамгын газраас сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж буй төслийн саналын төсвийн тооцоо алдаатай байх болон төслийн нэгдсэн жагсаалтыг журамд заасан маягтын дагуу бэлтгэхгүй байх дутагдал гарч байна. Жишээлбэл, Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газраас 2014 оны орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэх төслийн саналын төсвийн тооцоо алдаатай байснаас иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төслийн жагсаалтыг засаж сайжруулахаар сумын Засаг даргын Тамгын газарт буцааж байсан юм. Мөн төслийн нэгдсэн жагсаалт бэлтгэхдээ журамд заасан маягтыг зөвхөн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газар 2014 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн жагсаалт бэлтгэхэд ашигласан байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2013 оны орон нутгийн хөгжлийн сангаас Батсүмбэр суманд 249,300,000 төгрөгийн өртөгтэй 11, Баяндэлгэр суманд 159,200,000 төгрөгийн өртөгтэй 9, Баянчандмань суманд 150,300,000 төгрөгийн өртөгтэй 9 төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхээр тус тус баталжээ.	{ 63.4. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 63.3-т заасан саналыг хэлэлцэж, төсвийн төсөлд тусган, батлана. }
---	---

2014 оны орон нутгийн хөгжлийн сангаас Батсүмбэр суманд 291,993,000 төгрөгийн өртөгтэй 12, Баяндэлгэр суманд 199,397,200 төгрөгийн өртөгтэй 11, Баянчандмань суманд 188,242,100 төгрөгийн өртөгтэй 11 төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхээр тухай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан байна.

2012, 2013 онд Батсүмбэр, Баяндэлгэр болон Баянчандмань суманд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр иргэдийн зүгээс дэвшүүлсэн саналын тоог сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан саналын тоотой харьцуулбал:



Батсүмбэр, Баяндэлгэр болон Баянчандмань сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2013 онд дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэхээр баталжээ:

Сум	Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн нэр	Төсөв /төгрөг/
Батсүмбэр	-Сумын төвийн гудамжинд гэрэлтүүлэг хийх -Үдлэг багийн халуун усны барилга барих -Баянгол багийн явган гүүр барих -Цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа барих -Ковш худалдан авах -Ундны усны цэвэршүүлэх төхөөрөмж худалдан авах -Хог тээвэрлэлтийн ажиллах хүчний зардал -Сумын баяр наадам тэмдэглэх -Стадионы засвар үйлчилгээ хийх -Гудамжийн гэрэлтүүлгийн цахилгааны зардал -Гудамжийн гэрэлтүүлгийн урсгал зардал	249,300,000
Баяндэлгэр	-Халуун ус, ахуйн үйлчилгээний цогцолбор барих -Малын үүлдэр угсаа сайжруулах	159,200,000

	-Наадмын талбайг барьж дуусгах, тохижуулах -Нийтийн бохирын цооног барих -Хогийн цэгийг стандарт болгох, туурь хог цэвэрлэх -Хадлангийн пресс худалдаж авах -Интернет суваг тавиулах суурь зардал -Автобусны буудал бариулах -Авто гараж бариулах -Баяр наадам тэмдэглэх	
Баянчандмань	-Сумын баяр наадам тэмдэглэх -Хог хаягдал цэвэрлэх, зөөвөрлөх -Төвийн гудамжийн гэрэлтүүлгийг засварлах -Сумын төвийн төвлөрсөн халаалтын трассын зураг төсөл боловсруулах -2,4-р хороонд 5 гэрэлтүүлэг шинээр тавих, засварын шат авах -Хороод руу явсан зам, төв гудамжийн явган зам, үерийн суваг засах -Худгуудад цэвэршүүлэх төхөөрөмж тавих -Мал үржлийн үйлчилгээнд хээлтүүлэгч авах -Байгаль сууринд трансформатор авах	150,300,000

2014 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэхээр баталжээ:

Сум	Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн нэр	Төсөв /төгрөг/
Батсүмбэр	-4 багт худаг барих -Цамхагт гэрэл -Ёслол хүндэтгэлийн өргөө барих -1250 метр явган зам барих -Хүүхэд залуучуудын тоглоомын талбай барих -Электрон самбар худалдан авах -Наадмын талбайн засвар хийх -Төсөвт байгууллагуудын барилгын гадна засвар -Гудамжийн гэрэлтүүлгийн ашиглалтын зардал -Баяр наадмын зардал -Үдлэг багийн халуун усны барилга барих үлдэгдэл -Тухайн онд баригдах барилгын зураг төсвийн үнэ	291,993,000
Баяндэлгэр	-Нийтийн эзэмшлийн дулаан гараж барих -Сумын өндөрлөг байгуулах -Иргэдийн сургалт мэдээллийн төвийг тохижуулах -Баруун хорооны худаг тохижуулах -Интернетийн сүлжээнд холбогдох	199,397,200

	-Мал угаалгын ванн барих -Д.Нацагдоржийн нэрэмжит талбайг тохижуулах -Гэр хорооллын гэрэлтүүлгийн зардал -Сүүний хөргүүр худалдан авах -Орон нутгийн телевизийн тоног төхөөрөмж худалдан авах -Сумын төвийн зам засварын зардал	
Баянчандмань	-Наадам тэмдэглэх -Хог хаягдал зөөх, тээвэрлэх -Төвийн гудамжийн гэрэлтүүлгийг засварлах -Байгаль суурингийн трансформаторын үлдэгдэл -Золбин нохой устгах -Жишиг гудамж байгуулах -Соёл амралтын хүрээлэн байгуулах -Үр тарианы үрлэгч болон пресс худалдан авах -Орон нутгийн телевизийн хөрөнгө оруулалт -Ханангийн үүрийн худаг засвар -Фермийн хороо руу гэрэлтүүлэг тавих -2013 оны орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл мөнгө	188,242,100

ДҮГНЭЛТ

1. Төв аймгийн Батсүмбэр, Баянчандмань болон Баяндэлгэр суманд орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах талаар Төсвийн тухай хуулийн 63-р зүйлийн хэрэгжилт хангалтгүй байна.
2. Иргэдийн саналыг асуулгын хуудсаар насанд хүрсэн иргэн бүрээс авахгүйгээр, багийн иргэдийн Нийтийн Хурал дээр бүлгийн ярилцлагаар болон цахим хэлбэрээр авах явдлаар хязгаарлах тохиолдол байгаа учраас олон нийтийн нээлттэй санал асуулга иргэдийг бүрэн хамрахгүй байна.
3. Орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлж болох төслүүд, өмнөх жилүүдэд хэрэгжсэн хөрөнгө оруулалт, асуулгын хуудсаар иргэдээс өгсөн саналын урьдчилсан жагсаалт зэрэг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг багийн Иргэдийн Нийтийн хурлын өмнө иргэдэд гүйцэд, журамд заасан хугацаанд өгөхгүй, мөн хурлын үеэр бүрэн хэлэлцэхгүй байгаагийн улмаас орон нутгийн төсвөөр хэрэгжих ажлуудыг эрэмбэлэн сонгох явцад иргэд үр дүнтэй оролцож, мэдээлэлд суурилсан сонголт хийх боломж нь хязгаарлагдмал байна.
4. Сумын Засаг дарга журамд заасны дагуу сумын хөгжлийн бодлоготой уялдсан төслийн саналыг бэлтгэж, багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэхгүй байгаа учраас орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр иргэдийн санал болгож буй төсөл, хөтөлбөрүүд нь тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдахгүй байх явдал гарч байна.

ЗӨВЛӨМЖ

Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог сайжруулахад чиглэсэн дараах зөвлөмж гаргаж байна:

1. Сумын Засаг дарга, сумын Засаг даргын Тамгын газрын ажилтнууд болон багийн Засаг дарга нар Төсвийн тухай хууль болон Орон нутгийн төсөв боловсруулах журамд төсвийн үйл явцад иргэдийн оролцоог хангах талаар тусгасан зүйл, заалтыг судалж, хэрэгжүүлэх.
2. Багийн Засаг дарга нар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар олон нийтийн нээлттэй санал асуулга явуулахдаа иргэдийг бүрэн хамруулж байх. Энэ хүрээнд асуулгын хуудсаар багийн айл өрх бүрээс саналыг нь авч байх.
3. Орон нутгийн хөгжлийн сан гэж юу болох, тус сангаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн талаар иргэд саналаа ямар аргаар өгч болох болон саналаа өгөхөд нь шаардлагатай мэдээллийг (өмнөх жилүүдэд хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийн мэдээлэл, тухайн суманд хуваарилагдах хөрөнгийн урьдчилсан тооцоо, орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэхийг хориглосон хөтөлбөр, төслийн мэдээлэл г.м) санал асуулга явуулахаас өмнө иргэдэд энгийн, ойлгомжтой байдлаар хүргэж байх.
4. Нээлттэй санал асуулгын явцад болон багийн иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг хэлэлцэж, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгох зорилготой багийн иргэдийн Нийтийн Хурлын бэлтгэл ажил, хуралдааны зохион байгуулалтыг сайжруулах. Энэ хүрээнд хурлын зар, холбогдох мэдээллийг иргэдэд хүртээмжтэй байдлаар түгээх болон иргэдийн Нийтийн Хуралд оролцогчдыг идэвхжүүлэх, иргэдийн үр дүнтэй оролцоог хангах шинэлэг аргуудыг нэвтрүүлэх.
5. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тухайн жил орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрүүд, мөн өмнөх жилийн санхүүжилтээр хэрэгжсэн ажлын үр дүнгийн талаар сумын Засаг даргын Тамгын газраас иргэдэд цаг тухайд нь мэдээлж, иргэдэд хяналт тавих боломж олгох.

НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Мониторингийн дүнг олон нийтэд танилцуулах болон шийдвэр гаргагчдад уламжлан Төсвийн тухай хуулийн “орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах” тухай 63-р зүйлийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр дараах нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн болно:

Мониторингийн дүнгийн мэдээллийг “Төв Таймс” сонины 2014 оны 3-р сарын дугаарт нийтэлж, www.tuv.mn веб сайтад тавьж, аймгийн TBS телевизээр 2 удаа танилцуулж, мөн Баянчандмань, Батсүмбэр, Баяндэлгэр сумдад хэлэлцүүлэг хийх үеэр тус бүр 1 удаа 5 минутын мэдээлэл хийж, олон нийтэд сурталчилсан юм.

Мониторингод хамруулсан сум, багийн удирдлагуудтай хийсэн хэлэлцүүлэг, ярилцлагын үр дүнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөлтөд иргэдийг оролцуулах хандлага нэмэгдэж, өмнөх жилүүдийн алдаа дутагдлыг засаж сайжруулахад чиглэсэн алхмууд хийгдэж байна. Тухайлбал, 2014 онд асуулгын хуудсаар иргэдээс авсан саналын тоо 2 дахин өссөн бөгөөд Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх Орон нутгийн төсөв боловсруулах журмын хэрэгжилт сайжирч байна. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх жагсаалтыг хэлэлцэн батлах явцад сумын ИТХ төлөөлөгч, багийн ИНХ-ын дарга нарын оролцоо мэдэгдэхүйц сайжирсан юм.